

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ.

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан
огноо:

2023.12.27

Байгууллагын нэр:

Цагдаагийн ерөнхий газар

Нэгжийн нэр:

Нутаг дэвсгэр хариусан цагдаагийн
байгууллага

Албан тушаалтны нэр:

Эрүүлжүүлэх, саатуулах байрны дарга, эмч

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

ТТ-6

Ажлын цаг:

12 цаг

Ажлын байрны албан ёсны нэршил:

Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн
байгууллагын байр

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Байгалийн гамшиг, гал түймэр, хүн, малын
гоц халдварт өвчин гарсан, гэнэтийн болон
бусад аюул тохиолдсон, нийтийн эмх
замбараагүй байдал үүссэн, террорист
халдлага онц болон дайны байдал зарласан,
онц ноцтой гэмт хэрэг үйлдэгдсэн зэрэг
зайлшгүй тохиолдолд өндөржүүлсэн бэлэн
байдалд ажиллах.

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ.

Албан тушаалын зорилго:

Эрүүлжүүлэх, саатуулах байр болон ажиллагсдын хэвийн үйл ажиллагааг хангах, эрүүлжүүлэгдсэн, саатуулагдсан, архидан согтуурахтай тэмцэх, хяналт тавих чиглэлээр иргэдийн амь нас, эрүүл мэндийг хамгаалахад чиглэгдсэн ажил арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх, өдөр тутмын хяналт тавьж, хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх, удирлагаас өгсөн үүрэг, ажлын чиглэл, биелэлтийг хангаж ажиллах.

Албан тушаалын зорилт:

1. Эрүүлжүүлэх, саатуулах байртай холбогдох хууль, журам, стандартаар тавигдах шаардлагад нийцүүлэх болон ажиллагсдын хэвийн үйл ажиллагааг хангах, эрүүлжүүлэгдсэн, саатуулагдсан иргэдийн амь нас, эрүүл мэндийг хамгаалахад чиглэгдсэн ажил арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх, өдөр тутмын хяналт тавьж, алба хаагчдыг мэргэжлийн удирдлагаар хангах, цагдаагийн үйлчилгээг шуурхай хүртээмжтэй хүргэх ажлыг зохион байгуулах.

2.Архидан согтуурахтай тэмцэх, хяналт тавих чиглэлээр удирдах дээд байгууллагаас өгсөн үүрэг, тушаал, шийдвэр, аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас гарсан тогтоолыг хэрэгжүүлэх чиглэлээр алба хаагчдыг мэдээллээр хангаж тодорхой ажил зохион байгуулах, үр дүнг тооцох.

3.Хууль тогтоомж, дүрэм, журмаар хүлээлгэсэн ажлын байрны зорилгод нийцсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах-Т, Хариуцан Гүйцэтгэх-Г, Хянах-Х, Шийдвэрлэх-Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.1.Цагдаагийн албаны тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хууль, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмуудыг мөрдлөг болгон зөрчил гарган эрүүлжүүлэгдсэн, саатуулагдсан этгээдийг журмын дагуу хүлээн авч, эрүүл мэндийг хамгаалан хяналт тавин ажиллах, шаардлагатай тохиолдолд эмнэлгийн байгууллага, ар гэр, асран хамгаалагчид хүлээлгэн ажлыг зохион байгуулан ажиллана;	Нийтийн хэв журам хамгаалах ажлын үр дүн бодитой үнэлэгдэж, үйл ажиллагаа сайжирна.	Г
	1.2.Өвдөлт зовиуртай, архаг хууч өвчтэй, өндөр настай, тахир дутуу хүмүүст эмнэлгийн анхан шатны тусламжийг түргэн шуурхай хүргэж, шаардлагатай тохиолдолд эмнэлгийн байгууллага, ар гэр, асран хамгаалагчид хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулж ажиллана		Г
	1.3.Өөрийн болон бусдын эрүүл мэнд, амь насанд аюул учруулж болзошгүй нөхцөл байдал үүссэн үед тусгаарлах, нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэх арга хэмжээг авахад биечилсэн хяналтыг тавина;		Г
	1.4.Эрүүлжүүлэгдсэн этгээдээс эрүүлжүүлэх үйлчилгээний хөлсийг хураан авч, Төрийн санд тушааж ажиллана.		Г
	1.5.Эрүүлжүүлэх, саатуулах байрны хэвийн үйл ажиллагааг хангах, иргэдийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах, цагдаагийн үйлчилгээг шуурхай хүртээмжтэй хүргэх ажлыг зохион байгуулах;		Г
	1.6.Эрүүлжүүлэх, саатуулах байранд тавих хяналт шалгалтыг сайжруулах, иргэдийн амь нас, аюулгүй байдал, хууль ёсны эрхийг хангаж, ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөл, эмнэлгийн үйлчилгээ, ерөнхий шаардлагыг хангаж ажиллах;		Г
	1.7.Холбогдох дүрэм, журамд заасан бүртгэл, судалгаа, Цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн сангийн баяжилтад хяналт тавих;		Г,Т
	1.8.Эрүүлжүүлэх, саатуулах байрны үйл ажиллагаанд мөрдөх хууль, дүрэм, журам, зааврын хэрэгжилтийг хангах, дэг журам		Г

	<p>сахиулах, хяналт тавих алба хаагчдыг удирдан зохион байгуулж ажиллах;</p> <p>1.9.Эрүүлжүүлэх, саатуулах байранд тавигдах шаардлагад нийцүүлэх ажлыг зохион байгуулж, шаардлагатай эд зүйл, тусгай хэрэгсэл, эмнэлгийн анхан шатны тусламжид зориулагдсан эм тариа, материалын холбогдох судалгааг тухай бүр танилцуулах, хангалтыг тухай бүрт хийлгүүлэх;</p> <p>1.10.Эрүүлжүүлэх, саатуулах байр, үйл ажиллагааны талаар газар, хэлтэс, тасгийн удирдлагыг мэдээ, мэдээллээр хангах;</p> <p>1.11.Цагдаагийн байгууллагад хуулиар харьяалуулсан зөрчлийн талаархи гомдол, мэдээллийг хүлээн авч, зөрчлийн хэрэгт хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулж, шалган шийдвэрлэх;</p>		Г
			Г
			Г
2 дугаар зорилтын хүрээнд	<p>2.1.Эрүүлжүүлэх, саатуулах байрны үйл ажиллагаа, техник хэрэгсэл, эрүүл ахуй, ариутгал, халдваргүйжүүлэлт, ажиллагсдын эрүүл мэнд, хортой нөхцлийн талаар шаардлагатай мэдээ, мэдээлэл, санал, танилцуулгыг боловсруулж, удирдлагадаа танилцуулах;</p> <p>2.2.Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг дуудлага мэдээлэлд үнэлэлт дүгнэлт хийж шалтгаан нөхцөлийг судалж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх;</p>		Г
			Г
3 дугаар зорилтын хүрээнд	<p>Ажлын байрны зорилгын хүрээнд явуулах бусад үйл ажиллагаа:</p> <p>1.Хууль тогтоомж, дүрэм, журмаар хүлээлгэсэн ажлын байрны зорилгод нийцсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.</p> <p>2. Шууд удирдах албан тушаалтнаас өгсөн хууль ёсны үүрэг даалгаврын биелэлтийг хангах</p> <p>3. Албан хэрэг хөтлөлт, архивын журмыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах</p> <p>4. Төрийн алба хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлж, байгууллагын ажилтнууд болон харилцагч, үйлчлүүлэгчид иргэдтэй зөв боловсон харьцах ёс зүйн зөрчил дутагдал гаргахгүй байх.</p> <p>Шударга ёсны шалгуурыг хангах, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх талаар:</p> <p>1.Авлига, хүнд суртлаас ангид байж хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн, шударга ёсыг эрхэмлэн “Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг чанд сахих;</p> <p>2.Явцуу эрх ашиг сонирхолоос татлгалзаж, цагдаагийн байгууллага, албаны нийтлэг эрх ашиг сонирхлыг эрхэмлэн ажиллах.</p>	<p>Ажлын байрны зорилго, зорилт хангагдаж, цагдаагийн алба хаагчийн хуулиар хүлээсэн нийтлэг чиг үүргийн биелэлт хангагдана</p>	Г
			Г
			Г
			Г
			Г

III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх.	
Мэргэжил	Эрх зүй /0421/, Анагаах ухаан /091201/	
Мэргэшил	Албан тушаалын мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж, төгссөн байх.	
Туршлага	Цагдаагийн байгууллагад 5-аас доошгүй жил ажилласан, үүнээс офицерын албан тушаалд 2-оос доошгүй жил ажилласан байх.	
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	-Мэдээлэл дэх дутуу, алдаатай, нийцтэй бус байдлыг илрүүлэх. -Гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах. -Судалгааны ерөнхий арга зүйн мэдлэгтэй
	Асуудал шийдвэрлэх	-Өөрийн чиг үүргийн хүрээнд шийдлийн хувилбарыг боловсруулж, хариуцах. -Шаардлагатай асуудлаар судалгаа хийж, дүнг хариуцах.
	Багаар ажиллах	-Өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг бат хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах. -Бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох.
	Бусад	-Албан хэрэг хөтлөх, баримт бичиг боловсруулах. -Албаны болон хувийн нууцыг хадгалах. -Монгол хэлний зөв бичгийн дүрэм, найруулга зүйн мэдлэг сайтай байх

IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:
Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:

**Бусад харилцах субъект
Шууд харилцах:**

Хариуцсан асуудлаар бусад яам, агентлагийн албан тушаалын адил болон түүнээс доош зэрэглэлтэй албан тушаалтан;

Шууд бус харилцах:

Төрийн бус байгууллага, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, олон улсын байгууллага;
/Эдгээртэй харилцахдаа Цагдаагийн албаны тухай хууль, бусад хууль тогтоомж, үйл ажиллагааны журмын холбогдох заалтыг баримтална./

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:

Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:

Албан тушаал:

Байгууллагын нэр:.....

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДЭД ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Шийдвэрийн огноо:.....

Дугаар:.....



Т.ГАНЗОРИГ

2023 оны 12 дугаар сарын 27 ны өдөр

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр: ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

Шийдвэрийн огноо: 2023 оны 12 дугаар сарын 27 өдөр.

Дугаар: 1/401

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА



Т.СҮХБОЛД

2023 оны 12 дугаар сарын 27-ны өдөр

Танилцсан:

Танилцсан албан тушаалтан:

20... оны дугаар сарын-ны өдөр